



**БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 10 сарын 16 өдөр

Дугаар A/08

Улаанбаатар хот

┌ Ёс зүйн дэд хороо байгуулах тухай ┐

Монгол улсын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын 2.1.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор батлагдсан Бэлчээрийн менежмент төслийн нэгж орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 2.3, 5.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын албан хаагчдын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх, ёс зүйн байдалд хяналт тавих, сахилга ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн гомдол мэдээллийг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ёс зүйн дэд хороон дарга:
Гишүүн:
Нарийн бичиг:

Төслийн менежер
Агрономч
Хүний нөөц, бичиг хэргийн мэргэжилтэн

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ёс зүйн дэд хороонд үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/05 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР

31400000008